

БАТЛАВ.
САНГИЙН
САЙД

БАТЛАВ.
МОНГОЛ УЛСЫН
САЙД, ЗАСГИЙН
ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА

БАТЛАВ.
МОНГОЛ
УЛСЫН ШАДАР
САЙД БӨГӨӨД
ЭДИЙН ЗАСАГ,
ХӨГЖЛИЙН
САЙД

БАТЛАВ.
ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД
ХЭРГИЙН
САЙД

БАТЛАВ.
ГАДААД
ХАРИЛЦААНЫ
САЙД

Б.ЖАВХЛАН

Д.АМАРБАЯСГАЛАН

Ч.ХҮРЭЛБААТАР

Х.НЯМБААТАР Б.БАТЦЭЦЭГ









**МОНГОЛ УЛС, ДЭЛХИЙН БАНКНЫ ОЛОН УЛСЫН ХӨГЖЛИЙН АССОЦИАЦИ
ХООРОНДЫН "УХААЛАГ ЗАСАГ-2 ТӨСӨЛ"-ИЙН ЗЭЭЛИЙН ХЭЛЭЛЦЭЭРИЙГ
СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

**Нэг.Хууль тогтоомжийн төсөл боловсруулах болсон үндэслэл,
шаардлага**

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн хуралдааны 56 дугаар тэмдэглэл, Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо, Инновац, цахим бодлогын байнгын хороо, Эдийн засгийн байнгын хорооны 2022 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн хуралдаан, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2022 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн хуралдааны санал, дүгнэлт болон Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 220 дугаар захирамжийг үндэслэн Монгол Улс, Дэлхийн банкны Олон улсын хөгжлийн ассоциаци хоорондын "Ухаалаг засаг-2 төсөл"-ийн Зээлийн хэлэлцээрт Сангийн сайд Б.Жавхлан 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр гарын үсэг зурсан.

Монгол Улс, Дэлхийн банкны Олон улсын хөгжлийн ассоциаци хоорондын "Ухаалаг засаг-2 төсөл"-ийн Зээлийн хэлэлцээр нь Олон улсын гэрээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2-т заасны дагуу гадаад улс, олон улсын байгууллага, гадаад улсын болон олон улсын банк, санхүүгийн байгууллагаас авах зээлийн ерөнхий нөхцөлийн талаарх олон улсын гэрээ тул Улсын Их Хурлаар заавал соёрхон батлуулах шаардлагатай юм.

**Хоёр.Хууль тогтоомжийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах
харилцаа, хамрах хүрээ**

Хуулийн төсөл нь 1 зүйлтэй байх бөгөөд тус зүйлд Монгол Улс, Дэлхийн банкны Олон улсын хөгжлийн ассоциаци хооронд 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр байгуулсан "Ухаалаг засаг-2 төсөл"-ийн Зээлийн хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон батлахаар тусгасан.

Гурав.Хууль тогтоомж батлагдсаны дараа үүсч болох эдийн засаг, нийгэм, хууль зүй үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Монгол Улс, Дэлхийн банкны Олон улсын хөгжлийн ассоциаци хооронд 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр байгуулсан "Ухаалаг засаг-2 төсөл"-ийн Зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийг баталснаар нийгэм, эдийн засаг, хууль зүйн аливаа серөг үр дагавар гарахгүй бөгөөд цахим үйлчилгээний үр ашиг, хэрэглээг сайжруулах, дижитал үр чадварыг дээшлүүлэх, дижитал технологид суурилсан ажлын байрыг нэмэгдүүлэх зэрэг ач холбогдолтой болно.

Дөрөв.Хууль тогтоомжийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Олон улсын гэрээний тухай, Хууль тогтоомжийн тухай болон бусад хууль тогтоомжид нийцүүлэх бөгөөд хуулийн теселтэй уялдуулан шинээр боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хууль байхгүй болно.

---о00---